

**ГХБХБГ-ЫН 5 ДУГААР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2018.05.10.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>2018 онд хийгдэх захиалгат газрын төлөв байдлын, чанарын хянан баталгаа хийлгэх нэгж талбарын судалгааг сум тус бүрээр гаргаж ГЗБГЗЗГ-т тоо болон цаасан хэлбэрээр хүргүүлэв.</p> <p>ГЗБГЗЗГ-ын бүс нутаг хот төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн А.Золжаргалд Хот төлөвлөлтийн баримт бичгийн мэдээлэл, Цэнгэл сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг DVD хуулж, албан тооттой хамт хүргүүлэв.</p> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй барилгад үйл ажиллагаа явуулахыг хориглосон аймгийн ЗД-ын захирамж гаргасан.</p> <p>Өлгий хотын төвд байгаа нийтийн орон сууцны орчны газрыг шинэчлэн тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн ЗД-ын захирамжаар томилов.</p> <p>Дэлүүн сумын ЗДТГ-ын байр, Хотгор багийн 50 хүүхдийн цэцэрлэг, Суат ХХК-ний ажилчдын орон сууц, 4-р багийн цэцэрлэг, Улаанхус сумын 50 хүүхдийн цэцэрлэг зэрэг барилгуудын байршлын схемийг хангагч байгууллага аймгийн МХГ, Өлгий сумын засаг даргатай зөвшилцөж батлав.</p> <p>Аймгийн Цагдаагийн газрын шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай тогтоолын дагуу 2 иргэний эзэмшил газрын үнэлгээг гаргаж цагдаагийн газарт хүргүүлсэн.</p> <p>Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлсэн 15 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад шинээр байгуулсан гэрээний дагуу газрын төлбөр ногдуулан ажиллав.</p> <p>Хил хамгаалах ерөнхий газар, ГЗБГЗЗГаараас тусгай хамгаалалтад авагдсан Булган сум, Алтай сумын Улаан хад баг, Ногооннуур сумын Цагааннуур тоосгонд байгаа газарт</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

газар дээр нь ажиллаж ирсэн.

Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. **Тухайлбал:**

Алтай сум: Шинээр газар эзэмшүүлэх 2, газрын маргаантай 3 өргөдлийн хүсэлтийг тус тус хүлээн авч бүртгэв.

Хар-бут голын голдирол болон эрэг орчмын хуурай хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах ажиллав.

Алтанцөгц сум: Энэ долоо хоногт ГХБХБГ-аас ирүүлсэн албан тоотыг хүлээн авч танилцан хянан баталгаа хийлгэх төрийн болон ААНБ-ын судалгааг гаргаж ГХБХБГ-ын явуулав.

Агс GIS-д өвөлжөө, хаваржаа бүртгэх ажлыг хийж 2-р багийн Засаг даргатай хамт ажиллаж 103 өвөлжөө, хаваржааг бүртгэв.

10 өргөдөл хүлээн авч танилцан 7 өргөдлийг шийдвэрлэж захирамжийн төсөл боловсруулав.

6 иргэнд газар өмчлүүлэх захирамж боловсруулан Засаг даргад батлуулав.


Бугат сум: 3 иргэнд кадастрын зураг гаргаж өгөв. 1 иргэнд газар эзэмших гэрчилгээ бичиж өгөв. 10 иргэний нэгж талбарын хувийн хэрэг бүрдүүлэв. 1 иргэнд газар өмчлөх захирамж гаргуулав. 1 иргэнд хадлан ашиглах гэрээ хийв. Газрын төлбөрт 45000 төгрөг оруулав.

Толбо сум: Шинээр газар эзэмшигч иргэдэд гэрчилгээ олгон улсын бүртгэлд тусган үйлчилж, хувийн хэрэг шинээр нээж ажилласан болно. Мөн гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар 24 иргэнд газар олголт хийсэн 8 өргөдөл хүлээн авч гомдлыг тухайн үед эзэнтэй хариу өгч ажиллаж байна.

Ногооннуур сум: 12 иргэнд кадастрын зураг, 3 иргэнд хянан баталгааны дүгнэлт гаргаж өгөв. 5 иргэнд үл хөдлөх хөрөнгийн материал бэлдэж өгөв. Сум, баг, малчдын судалгаанд координат байршлын судалгааг гаргаж өгөв. 7 иргэний материалыг сканердаж ЛМ-д оруулав. Газрын төлбөрт 22500₮ оруулав.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

**2018 ОНЫ 05 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ**

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт
2	“Соёлтой хот” сарын аяны хүрээнд байгууллага тус бүр идэвхтэй оролцож, гаднах орчныхоо талбайг цэвэрлэх, тохижилтыг сайжруулахад анхаарч ажиллах	7 хоног	Бүх байгууллагуудын дарга нарт	<p>“Соёлтой хот” сарын аяны хүрээнд байгууллагын гадна орчны талбайн цэвэрлэгээнд байгууллагынхаа бүх ажилтан, албан хаагч нарыг хамруулав.</p> 
3	Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан хашаа барих ажлыг дуусгаж, байгууллага бүр мод тарих бэлтгэл ажлаа ханган ажилчдаа бүрэн оролцуулах	7 хоног	БОАЖГ-ын дарга, СДОА-ийн дарга болон холбогдох бусад байгууллагуудын дарга нарт	Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан хашаа барих ажлын 100.000 төгрөгийг байгууллагаас гаргаж, холбогдох байгууллагад шилжүүлэв.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР